

ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS OF ENSURING INTERNAL SECURITY

Буяндэлгэрийн Ням-Очир*

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Lt. Col. Nyam-Ochir Buyandelger, Senior Lecturer, Border Protection Services Department, Border Protection Service School, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: buyandelgernyamochir@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын дотоод аюулгүй байдлын өнөөгийн байдалд хийсэн салбарын эрдэмтэн, судлаачдын судалгаанд тулгуурлан түүнийг хангахад тулгамдаж буй зарим асуудлыг судалж гаргах зорилгыг агуулсан. Улс үндэсний аюулгүй байдал дотооддоо аюулгүй байх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой. Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангахад үндэсний эв нэгдэл, авлигатай тэмцэх, улс төрийн намуудын төлөвшил, дотоод ардчилал, био аюулгүй байдал, эмийн чанар, хүнсний аюулгүй байдал, цус ойртох үзэгдэл зэрэг олон хүчин зүйл чухал үүрэгтэй. Цар тахал нийгэм эдийн засгийн хямрал үүсгэж, төр засгийн үл итгэх байдал нэмэгдсэнээр улс төрчид популизм хийж, олон нийтийг эмх замбараагүй байдалд турхирах хандлага ажиглагдаж байгаа нь судалгааны үр дүнгээр ажиглагдаж байна. Улс төрийн намуудын дотоод ардчилалгүй байдал, санхүүжилтийн хяналтгүй байдал нь иргэдийн хооронд талцан хуваагдах, эв нэгдэл алдагдах зэрэг сөрөг үр дагавартай юм. Монгол Улс био аюулгүйн хоёрдугаар зэрэглэлээс дээш түвшний лаборатори байхгүй нь үхлийн аюултай халдварт өвчний үед бэлэн биш байгааг харуулж байна. Үндэсний аюулгүй байдлыг хангахад соёлын биет бус өв, өвлөн уламжлагчдын тоо эрс цөөрсөн нь бага боловч асуудал болж байна. Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг оролцоо чухал болжээ. Судалгааны ажлыг эрдэмтдийн бичсэн бүтээл, судалгааны ажлуудаас цуглуулж, нэгтгэн дүгнэх, харьцуулах аргуудыг ашигласан болно.

Abstract: This article aims to examine some of the issues facing Mongolia's internal security based on research conducted by scholars and researchers on the current state of internal security. The national security of the country is of paramount importance. Many factors, including national unity, the fight against corruption, the maturity of political parties, internal democracy, biosecurity, drug quality, food safety, and incest, play an important role in ensuring Mongolia's internal security. The results of the study show that as the pandemic has caused a socio-economic crisis and distrust of the government has increased, politicians have a tendency to engage in populism and incite the public to chaos. The lack of internal democracy and lack of control over funding among political parties have negative consequences such as division among citizens and loss of unity. The lack of a laboratory above the second level of biosecurity shows that Mongolia is not prepared for a deadly infectious disease. The sharp decrease in the number of intangible cultural heritage and heirs is a small but significant problem in ensuring national security. The cooperation and role of organizations with special



Дотоод Аюулгүй Байдал
Урьдчилсан
Хамгаалалт





functions to protect national security has become important. The research work is collected from the works and research works written by scientists, and methods of summarization and comparison are used.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, биотероризм, хүн амзүй, үндэсний эв нэгдэл.

Keywords: Security, bioterrorism, demography, national unity.

Удиртгал

Улс үндэсний аюулгүй байдлыг хангах тулгуур зарчимд тухайн улс дотооддоо аюулгүй байх явдал тэргүүн зэргийн ач холбогдолтой. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийгмийн дотоод аюулгүй байдлыг хангах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэхдээ нийгмийн үнэт зүйлсийн нэгдмэл байдал, нийгмийн зөвшилцлийг бэхжүүлэх, дотоодын зөрчил, тэмцэлд хүргэх аливаа үйл явдлаас сэргийлэх зэрэг асуудал нэн чухал болохыг онцолдог. Гадаад орнуудын зүгээс аливаа улс оронд чиглэсэн бодлого хэрэгжүүлэхдээ тухайн улсын дотоод орчин, тэр дундаа нийгмийн сэтгэл зүйд нь нөлөөлж тогтворгүй байдал бий болгох, улмаар улс үндэстнийг эзлэн түрэмгийлэх арга технологи шинэ хэлбэрээр хөгжсөөр байна. Орчин үеийн аюулгүй байдлын салбарт гарч буй уламжлалт бус дайны энэхүү арга хэлбэрээс урьдчилан сэргийлэх, аюул эрсдэлийг таслан зогсооход хууль сахиулах байгууллагуудын үүрэг оролцоо, хамтын ажиллагаа нэн чухал ач холбогдолтой. Сүүлийн жилүүдэд манай улсын дотоод аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй дараах тулгамдсан асуудлууд байдаг. Эдгээр асуудлуудыг ач холбогдолоор жагсаавал үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдал, улс төрийн намуудын төлөвшил, Хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, био аюулгүй байдал, хүн ам зүйн байдал, соёлын өвийн гээгдэл зэрэг нь чухай байр суурь эзэлдэг. Эдгээр

асуудлуудаас хамааралтай аюулгүй байдлыг хангахад хууль сахиулах байгууллагуудын үүрэг оролцоо, хамтын ажиллагаа онцгой чухал. Гэвч “Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулиар тусгай чиг үүрэгтэй байгууллага улс орны аюулгүй байдлыг хангахдаа хэрхэн хамтран ажиллаж, мэдээлэл солилцох тухай тусгайлсан зохицуулалтгүй. Үүний улмаас тусгай чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг удирдлагын түвшинд уялдуулан зохицуулахад хүндрэлүүд тулгардаг.

Үндсэн хэсэг

Сүүлийн жилүүдэд манай улсын дотоод аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

1. Үндэсний эв нэгдэл

Аливаа улс үндэстэн бусад улсаас түүх, гарал үүсэл, хэл, соёл, зан заншил, шашин шүтлэг зэргээр ялгарч, үндэсний онцлогт хэв шинжийг бүрдүүлж байдаг. Энэхүү онцлог нь үндэсний эв нэгдлийн дархлааг тогтоож, ард түмний оюун санааны нэгдмэл байдлыг бий болгодог. Харин үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулдаг хамгийн бодитой, хамгийн том аюул бол дотоодын эв нэгдэл алдагдах явдал юм. Сүүлийн жилүүдэд гадна дотны улс төр, шашин соёлын нөлөөгөөр үндэсний эв нэгдэл сарниж, ард түмний үнэт зүйлийн нэгдмэл байдал алдагдаж болзошгүй нөхцөл үүсээд байна. Тухайлбал манай улсад үндэсний аюулгүй байдалд сөрөгөөр нөлөөлж болзошгүй олон янзын шашны гаж урсгалууд идэвхитэй

үйл ажиллагаа явуулах болсон. Стратеги судалгааны хүрээлэнгийн 2018 оны судалгаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт 1075 шашны байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 48.5 хувь нь христийн, 40.8 хувь нь буддын, 6.3 хувь нь исламын, 2.8 хувь нь бөө мөргөлийн, 1.5 хувь нь бусад шашны байгууллага байна (Стратеги судалгааны хүрээлэн, 2018а). Эдгээр шашны байгууллагын дотор бурханы шашин ба бөө мөргөл, исламын шашны сүм хийд, мөргөлийн төв, мечетээс гадна зарим улсад хориглож, үйл ажиллагааг нь хязгаарласан, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй шашны янз бүрийн гаж урсгалууд нэвтрээд байна. Шашны байгууллагын бүртгэл, мэдээллийн асуудал хариуцдаг үндэсний аюулгүй байдлын тусгайлсан чиг үүрэг бүхий Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар шашны байгууллагын тоон мэдээллийг гаргахдаа зөвхөн бүртгүүлэх хүсэлтээ ирүүлсэн шашны байгууллагын тоонд тулгуурлан гаргадаг бөгөөд зөвшөөрөлгүй ажиллаж байгаа шашны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй байна. Хууль сахиулах чиг үүрэгтэй цагдаагийн байгууллагад тухайн орон нутаг дахь шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хугацаа дуусах эсэх тухай мэдээлэл байдаггүй бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Стратеги судалгааны хүрээлэнгээс 2021 оны 5 дугаар сард гүйцэтгэсэн судалгаагаар Монгол Улсын үндэсний эв нэгдэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд нийгмийн ёс суртахууны доройтол, иргэдийн улс төрийн намаас болж талцан хуваагдах үзэгдэл, эх оронч үзэл төлөвшөөгүй

байдал, нутгархах үзэл зэрэг 16 хүчин зүйл нөлөөлж байна гэж үзсэн (Стратеги судалгааны хүрээлэн, 2021). Энэ байдал цаашид удаан үргэлжилбэл Монгол Улсын язгуур эрх ашиг, дотоод аюулгүй байдалд асар их хохирол учруулж болохоор байна.

2. Нийгмийн тогтвортой байдал

Цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн таагүй байдал бий болж, ажилгүйдэл, ядуурал өсөхийн хэрээр иргэдийн бухимдал нэмэгдэж, төр засагт үл итгэх байдал ихээр ажиглагдаж байна. Энэхүү нийгмийн бухимдлыг ашиглан улс төрчид, олны танил хүмүүс популизм хийж, төр засгийг үндсэн хуулийн бус аргаар өөрчлөх шаардлага тавьж, олон нийтийг эмх замбараагүй байдал, өдөөн хатгалгад турхирах байдал үе үе ажиглагдах боллоо. Олон нийтийн санаа бодлын тандалт судалгаанаас үзэхэд нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудал нэмэгдэж, шударга ёс алдагдах тусам олон нийт жагсаал цуглаанд оролцох магадлал нэмэгддэг байна (Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, 2013). Сант марал сангийн 2021 оны 4 дүгээр сард гүйцэтгэсэн судалгаагаар нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхгүй бол иргэдийн 50 орчим хувь нь жагсаал цуглаанд оролцох, иргэний нийгмийн байгууллагуулыг дэмжих, төр засгийг өөрчлөх шаардлага тавих зэрэг улс төрийн идэвхитэй үйл ажиллагаа явуулахад бэлэн байгаагаа мэдэгджээ. Ардчилсан засаглалын хөгжлийн харьцуулсан судалгааны чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлсэн зарим судалгааны дүнгээс үзэхэд (Азийн барометр, 2003) сүүлийн жилүүдэд ард иргэдийн олонх нь ардчилсан засаглалын хэрэгжилтэнд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсад





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠨᠠᠮᠤ ᠤᠯᠤᠰ

ардчилсан засаглал тохирохгүй гэж үзэх хүмүүсийн тоо нэмэгдсээр байна. АНУ болон баруун европын орнуудтай харьцуулахад шинээр ардчилал тогтсон орны иргэдийн хувьд авторитар дэглэмийг санагалзах, нийгмийн өөр зохион байгуулалтыг эрэлхийлэх хандлага ихээхэн ажиглагдаж байна. Зарим нөхцөлд ардчилсан бус засаг ардчиллаас илүү дээр байж болно гэх хандлага олонхийн буюу 37.4 хувийг эзэлж байна. Ардчилсан бус хүчтэй удирдагчтай байх үзэл санааг олон нийт дэмжих хандлагатай байгаа юм. Хүчтэй удирдагчтай байх үзэл санаанд нийгэм хөтлөгдөх тусам дарангуйллын тогтолцоо, төрийн эргэлт гарах, цэргийн дэглэм тогтох магадлал өндөр байдаг. Монголын нийгэм ийм хэв шинжийг бүрдүүлж байгаа тул засгийн эрхийг гартаа авах зорилго бүхий бүлэглэлүүд бий болох, гадаадын улс орнуудын дэмжлэгээр дотоодод нь хагалан бутаргах, нийгмийн тогтвортой байдал үүсгэж болзошгүй нөхцөл бүрдсэн байна.

3. Улс төрийн намуудын төлөвшил

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.2.2. дахь хэсэгт “Авлигатай хийх тэмцлийг үндэсний хэмжээнд өрнүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэй оролцоог хангана. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлнэ”, мөн 3.3.4.1 дэх хэсэгт “Ардчилсан тогтолцооны тулгуур болох улс төрийн намуудын төлөвшил, дотоод ардчиллыг дэмжиж, улс үндэстэн хийгээд нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг нь өндөржүүлнэ. Үндэсний язгуур эрх ашгийн үүднээс улс төрийн намын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвшилцөлд

хүрэх механизмыг хөгжүүлнэ” хэмээн улс төрийн нам бол засаглалын чухал институт болохыг онцолж, түүний төлөвшил, дотоод ардчиллыг бэхжүүлэх, авлигаас ангид байх нөхцөлийг бий болгох нь үндэсний аюулгүй байдлыг хангахад нөлөөлнө гэж үзсэн байдаг. Аливаа улсын ардчиллын чанар, бэхжилтийг хангахад улс төрийн нам хамгийн чухал үүрэгтэй. Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлан олон намын тогтолцоонд шилжсэн цагаас хойш улс төрийн намын тоо тогтмол өссөөр эдүгээ Улсын Дээд шүүхэд 36 улс төрийн нам бүртгүүлжээ. Улс төрийн нам гэдэг нь сонгуульд амжилттай оролцож засгийн эрхийг авахын төлөө улс орныг хөгжүүлэх “бодлого, мөрийн хөтөлбөр”-ийг сонгогчдод санал болгодог улс төрийн институт. Сонгуульд амжилттай оролцох, сонгуулийн бус үед улс төрийн үйл ажиллагаа явуулж улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, намын бүтцийг тогтвортой ажиллуулах, үүний тулд тухайн улс төрийн намын гишүүд намын шийдвэрлэх ёстой аливаа асуудалд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, оролцдог, төлөөлөх түвшний бүх сонгуульд хүйс харгалзахгүйгээр нэр дэвшин өрсөлдөх, нэр дэвшигчид саналаа өгөх, намын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах, хянах зэргээр намын үйл ажиллагаанд оролцдог хариуцлагатай гишүүдтэй байх нь намын төлөвшил, дотоод ардчиллыг тодорхойлдог. Гэвч Монгол Улсад буй улс төрийн намуудын төлөвшил, чанарын асуудалд улс төр судлаачид төдийгүй нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандсаар ирлээ. Улс төрчид, намуудын зүгээс ардчиллын наад захын зарчмуудыг хэрэгжүүлэхгүй, хууль бус арга хэрэглэх, өөрт ашигтай бизнесийн

тендерийг авах, иргэдийн эрх ашгийг зөрчих, авлига хээл хахуульд автах зэрэг олон сөрөг үзэгдэл үүсгэж байгааг дурьдаж болно. Үүний гол шалтгаан нь улс төрийн намууд дотоод ардчилалгүй, намын санхүүжилтийн далд бөгөөд хяналтгүй байдал, эрх ашгийн төлөө улайран тэмцдэг, өндөр түвшний авлигатай холбогдсон зэрэг асуудал байна (Б.Эрдэнэдалай, 2020). Энэ бүхнээс үүдэлтэй иргэд хоорондоо улс төрийн намаас болж талцан хуваагдах, дотоодын эв нэгдэл алдагдах, нийгмийн сэтгэл зүйн хямралт байдлыг бий болгож буй үзэгдэл түгээмэл ажиглагдаж байна.

4. Ковид-19 цар тахал ба био аюулгүй байдал

Шинэ төрлийн коронавирусийн халдварын тархалт Монгол Улсын дотоод аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт томоохон сорилт, бас сургамж, дохио болсон. Цаашид ийм төрлийн онц аюултай халдварт өвчин дэгдсэн тохиолдолд манай улс өнөө хэр бэлэн биш байна. Био аюулгүй байдлыг хангах, цар тахлаас урьдчилан сэргийлэх асуудал бидний анхаарлын гадна талд орхигдсоор иржээ. Ковид-19 цар тахлын хамарч буй хүрээ, тархалтын хурд, үргэлжилж буй хугацаа, халдварлах зам болон эмнэл зүйн шинж тэмдгийн олон янз байдал зэрэг нь вирусийн шалтгаант аливаа халдварт өвчний тархвар зүйн нийтлэг онцлогоос ихээхэн өөр байгаатай холбогдуулан үүсгэгч вирусийн гарал үүслийн талаар янз бүрийн таамаг дэвшүүлэхэд өөрийн эрхгүй хүргэж байсан. Ковид-19 цар тахлын дэлхий дахины хөнөөлт үр дагавар асар их, мөн үүнийг биотеррор үйл ажиллагаа хэмээн үзэх хардлага түгээмэл байгаагаас үүдэн улс орнууд био аюулгүй байдал, био хамгааллын асуудлаа өндөр дээд түвшинд,

нухацтай авч хэлэлцэх зүй ёсны шаардлага үүсээд буй.

Халдварт өвчин үүсгэгч бичил биетнийг аюулын зэрэглэлээр 4 ангилдаг бөгөөд эдгээр үүсгэгчтэй био аюулгүйн III, IV зэрэглэлийн лабораторид ажиллах ёстой. Гэтэл Монгол Улсад био аюулгүйн II зэрэглэлээс дээш түвшний лаборатори байхгүй нь үхлийн аюултай халдварт өвчний үед бид бэлэн биш, барьц алдах нэг том шалтгаан болсон. Ковид-19 цар тахал нь вирусийн шалтгаант, үхлийн аюултай халдварт өвчний анхны тохиолдол биш бөгөөд сүүлчийнх ч бас биш юм (Энхмаа & Ариунболд, 2020). Иймд Монгол Улсын био аюулгүй байдлыг хамгаалах үндэсний тогтолцоог бүрдүүлэх, ялангуяа хууль хүчний байгууллагууд зарим чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

5. Хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал

Монгол Улсын дотоод аюулгүй байдлын салшгүй хэсэг бол нийт хүн амын эрүүл, аюулгүй амьдрах баталгааг хангах явдал юм. Ковид-19 цар тахал манай улсын эрүүл мэндийн тогтолцоо хэр хүчин чадалтай байгааг бидэнд харуулсан. Эрүүл мэндийн салбарын тогтолцоог сайжруулахын тулд эмчилгээ, үйлчилгээ, эмийн чанарыг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай. Ялангуяа эмийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах нь тулгамдсан асуудал болж байна. Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмийн зохицуулалтын алба болон Гаалийн ерөнхий газрын барааны ангилал, үнэлгээний хэлтсийн хамтран боловсруулсан Монгол Улсад бүртгэлтэй эмийн кодолсон жагсаалтад нийт 3944 эм бүртгэлтэй байгаагаас 3391 нь буюу 86 хувь нь импортын эм, 553 буюу 14 хувь нь дотоодын





үйлдвэрийн эм байна. Дотоодын үйлдвэрийн нийт 553 эмийн 267 (48,3%) нь европ эм, 286 (51,7%) нь уламжлалт эм байгаа нь дотоодын эм үйлдвэрлэлээ дэмжих бодлого дутмаг байгаагийн нэг илрэл юм. Монгол Улсад эмийн чанар, аюулгүй байдлыг шалгаж шинжилдэг нэг ч лаборатори байхгүй. Гэтэл дэлхийн 47 улсаас 3391 эм импортоор авдаг нь эмийн зохисгүй хэрэглээг үүсгэж, эмийн аюулгүй байдал хангагдахгүй байгаагийн тод жишээ юм (Стратеги судалгааны хүрээлэн, 2020). Монгол Улс өдгөө дэлхийн улс орнуудаас хорт хавдрын өвчлөл хамгийн ихтэйд тооцогдож, түүний дотор элэг, ходоодны хорт хавдар хамгийн их байгаа нь хоол хүнсний асуудал ихээхэн тулгамдаж байгааг харуулж байна. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл хот хөдөөд ялгаагүй өсөх хандлагатай, нийслэлд бүр их өссөн, 9-өөс 10 хүн тутмын нэг нь хоол боловсруулах тогтолцооны өвчтэй байна. Аймаг, орон нутагтай харьцуулбал нийслэлийн хүн амын хүнсний хэрэглээний сагсанд импортын хоол хүнс харьцангуй их байгаа бөгөөд энэ нь өвчлөл ихсэх шалтгаан болж байх магадлал өндөр. Монгол Улсын хилийн 26 боомтын 22-оор жилд ойролцоогоор 270000 тонн хүнс импортолдог. Энэ нь нэг Монгол хүн жилд дунджаар 90 кг импортын хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг гэсэн үг. Стратеги судалгааны хүрээлэнгийн Нийгэм, төрийн судалгааны секторын 2017-2018 онд хийж гүйцэтгэсэн “Хүнсний импортын хяналтыг сайжруулах нь” бодлогын судалгааны үр дүнд импортын хяналт шалгалтын тогтолцоо сул, дутмаг байгаагаас хүнсний аюулгүй байдал алдагдаж байна. Энэ нь импортын хүнсний чанарын хяналтын шинжлэх, тайлагнах, мэдээлэх тогтолцоо огт

бүрдээгүйтэй холбоотой. Импортын хүнсний хяналтыг гүйцэтгэх лабораторийн чадавх сул, хүрэлцээгүйгээс импортын хүнсний аюулгүй байдлыг хянаж чадахгүй байна гэсэн дүн гарсан байна (Стратеги судалгааны хүрээлэн, 2018b).

6. Хүн ам зүйн байдал

Монголчууд овгоо хэрэглэж, гэрийн угийн бичгээ хөтөлдөг уламжлал тасарсан 1925 оноос хойш Монгол хүн өөрийн авга өвөг эцэг, эмэг; нагац өвөг эцэг, эмгээс урагш түвшинд ураг төрөл, садан сүлбээний холбоотой хүмүүс, тэдний үр удмын тухай мэдлэг, мэдээлэлгүй болсонтой холбоотой хүн амын дотор цус ойртох үзэгдэл үүсэж, даамжирсаар эдүгээ үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц түвшинд хүрчээ. Мөн ураг төрөл, садан сүлбээний харилцаа, холбооны хүрээ ийнхүү хумигдахын хэрээр монголчуудын эв нэгдлийн язгуур чанар суларсан.

Өргөн уудам нутаг дээр цөөн хүн амьдрах нь хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн эрсдэл дагуулдаг. Монгол Улсын засаг захиргаа өнөөгийн байдлаар 21 аймаг, 330 сум, 1639 багт хуваагдсан бүтэцтэй байгаа. Засаг захиргааны ийнхүү хэт жижиглэсэн бүтэц нь хүн амын чөлөөт хөдөлгөөнийг хязгаарлаж цус холилдох үзэгдлийг түгжигдмэл байдалд оруулдаг сөрөг үр дагавартай.

Монгол Улсын хүн амд өөрөөс дээш 3-4 дэх үеийн ах дүү нар гэрлэхэд илэрдэг цус ойртолт ($F_{IT}=0.0651$) бий болж, энэ нь бүх аймаг, сум, багийн хүн амд нийтлэг үзэгдэл болсныг хүн судлаач эрдэмтдийн олон жилийн генетикийн судалгааны үр дүнгүүд хөдөлбөргүй нотолдог. Түүнчлэн гэрлэлтийн тогтолцоо ихээхэн эвдэгдэж хөдөөгийн багийн хувьд нэг багийн уугуул хүмүүс хоорондоо

гэрлэх нь нийт гэрлэлтийн 85,4%, нэг сумын уугуул хүмүүс хоорондоо гэрлэх нь нийт гэрлэлтийн 73,9%, нэг аймгийн уугуул хүмүүс хоорондоо гэрлэх нь нийт гэрлэлтийн 86,1%-ийг тус тус эзэлдэг болсон. Төв суурин газар тийш чиглэсэн ганц урсгалт шилжих хөдөлгөөнтэй холбоотой хөдөө орон нутгийн хүн ам хэт цөөрч шууд бус цус ойртолтын түвшин сүүлийн 10 жилд 1,2-5,1 дахин өссөн. Хүн ам дахь цус ойртолтын өнөөгийн түвшин дараах ноцтой үр дагавар учруулж байна. Үүнд:

1. Өвчний олон улсын Х ангиллын 19 бүлэг өвчин, 32 төрлийн хорт хавдраар Монгол хүн өвдөж, эндэхэд цус ойртолт бодитой нөлөөлж байна.

2. Монгол Улсын хүн амд бүртгэгдсэн “Оюуны хомсдол”-ын нийт тохиолдлын тавин хувь нь цус ойртолтын шалтгаантай байна.

3. Төрөлхийн хөгжлийн согог, гажигтай хүүхэд аймаг бүрт мэндэлж, жил ирэх тусам тооны хувьд эрс өсөж, мэс заслаар ч шийдэх боломжгүй хүнд хэлбэрийн гажгууд илэрч байгаа нь цус ойртолттой шууд бөгөөд хүчтэй хамааралтай байна (Энхмаа, 2021).


Монгол Улсын хүн амын нягтрал, орон зайн байршлын хэт тэнцвэргүй

байдал нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангахад ихээхэн эрсдэл дагуулж байна. Судалгааны (Батсуурь & Энхмаа, 2017) үр дүнд хийсэн дүгнэлт:

1. Монгол Улсын нэг аймгийн хүн амын 60 гаруй хувь нь аймаг, сумын төвд, 40 орчим хувь нь хөдөөд амьдарч байгаа төдийгүй аймгийн төвийн хүн ам (38,2%) хөдөөгийн нийт хүн ам (39,4%)-тай ойролцоо байгаа нь манай улсын хүн амын орон зайн байршил ихээхэн тэнцвэргүй байдалд орсныг харуулж байна.

2. Аймаг, сумын төвийн суурин хүн амыг оруулан тооцсон хүн амын нягтралын газарзүйн тархалтын зургаас үзэхүл үндсэндээ Монгол орны өргөргийн 47⁰ градусаас 41⁰, уртрагийн 109⁰ градусаас 120⁰ градусын зурваруу ойртох тусам хүн амын суурьшлын хэт сийрэгжилт бий болсон үзэгдэл илэрлээ (Зураг 1).

3. Монгол Улсын хилийн дагуух сумдын хүн амын дундаж нягтрал хилийн бус сумдынхтай харьцуулахад 2 дахин бага, мөн өмнөд хөрштэй хил залгаа сумдад хүн амын дундаж нягтрал хойд хөрштэй хиллэдэг сумдынхаас 1,3 дахин бага байгаа нь хил хязгаар нутаг эзэнгүйдэж буйг гэрчилж байна.



Зураг 1. Хүн амын нягтралын газарзүйн тархалт. Эх сурвалж: Жамъяны Батсуурь, & Б. Энхмаа, (2017). Монгол Улсын хүн амын орон зайн байршил ба нягтралын газарзүйн тархалтын өнөөгийн байдал.





7. Соёлын өвийн гээгдэл

Аливаа түүхэн бүлэг ард түмэн буюу угсаатан, үндэстний хувьд төрөлх газар нутаг, уугуул ард түмний удмын сан, үндэсний уламжлалт соёл, тэдгээрийн нэгдэл бол үндэсний язгуур үнэт зүйлс нь болж байдаг. Төрөлх газар нутаг, удмын сан хоёрын нэгдлийг нөхцөлдүүлж аюулгүй өөрөөрөө оршин хөгжих нөхцөлийг хангаж байдаг тулгуур хүчин зүйл бол үндэсний уламжлалт соёлын тогтолцоо юм. Монгол уламжлалт нүүдлийн соёлын биет бус өвийн төрөл, өвлөн уламжлагчдын өнөөгийн дүр төрх нь “Эх хэл, аман уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрүүд”-ийн жишээн дээр хийсэн судалгааны үнэлгээгээр соёлын биет бус өвийн төрлүүдийг өвлөн уламжлагчдын тоо өнөөгийн Монголын хүн амын дотор эрс цөөрсөн үзэгдэл илэрч байна.

1. Монгол Улс 1921 оны Ардын хувьсгалын дараа үеэс 1990 хүртэлх 70 шахам жилийн хугацаанд уламжлалт өв соёлыг социалист нийгэмд харш, хуучин нийгмийн хоцрогдсон зүйл хэмээн үзэх болсноор соёлын өвөө хадгалах, үр хүүхэддээ өвлүүлэх боломж аажим хаагдсаар устах аюулын ирмэгт хүрсэн,

2. Монгол Улс 1990 оноос ардчилал, чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжих үед монголчууд уламжлалт соёлын өвөө бараг хэрэглэхээ больж хэт хөндийрч холдсон, бараг мартаж аюул нүүрлэсэн байдалд орсон,

3. 1990 оноос ардчилал, чөлөөт зах зээлийн нийгэмд шилжин орох үеэс өөрийн өв соёлоо бараг мартсан монголчуудад гадны соёлын бүхий л хэлбэрүүд онцгой сайхан зүйл мэт санагдаж тэдгээрээс эмх замбараагүй өөр өөрийн дур зоргоор хэрэглэх сэтгэлгээнд шилжсэн,

4. Монгол Улс ардчилал, чөлөөт зах зээлийн нийгэмд шилжсэн хугацаанд “Соёлын тухай”, “Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол Улсын хуулиудыг бий болгосон. Уламжлалт соёлын өв бол гагцхүү гэр бүл, бүх шатны боловсролын байгууллагаар дамжиж үр удамдаа өвлөгддөг жам ёсны хуультай. Гэтэл “Соёлын тухай” Монгол Улсын хуулинд соёлыг тээж түгээдэг этгээдийн бүрэлдэхүүнд иргэн, соёл урлагийн байгууллагыг оруулаад гэр бүл, боловсролын байгууллагыг орхигдуулсан,

5. 2010 онд баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа Соёл иргэншлийн аюулгүй байдлыг Оршин тогтнохуйн аюулгүй байдлын түвшинд авч үзэхээр баталгаажуулсан. Гэвч үндэсний соёл бол үндэсний оршин тогтнох, хөгжих суурь үндэс юм гэдэг ойлголт төрийн бодлого, нийгмийн сэтгэл зүйд суугаагүйгээс соёлыг үндсэн чиг үүргийн яамны түвшинд тавих нь бүү хэл салбарын тусгай яамны түвшинд ч авч үзэхгүйгээр өөр яамны хавсарга болгож олон жил явсан нь соёлын салбарын хөгжлийг уналтад оруулсан

Дээр дурдсан дүгнэлтүүдтэй холбогдуулан тэмдэглэхэд Монгол хүний үндэсний сэтгэл зүйг төлөвшүүлж, тэнцвэржүүлж, үр удамдаа өвлүүлэх жам ёсны үзэгдлийг зангидаж байдаг уламжлалт соёлын “ёс суртахууны хазаар” бүр үгүй болох аюул нүүрлээд байна (Батсуурь, 2017).

Дүгнэлт, санал

Монгол Улсын дотоод аюулгүй байдалд сөрөг үр нөлөөтэй, цаашид аюул эрсдэл өргөжих магадлалтай өнөөгийн нөхцөлд Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг оролцоо нэн чухал асуудал болжээ. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх

хэсэгт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийг дараах байгууллагууд хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах алба;
2. Гаалийн алба;
3. Дипломат алба;
4. Гамшгаас хамгаалах алба;
5. Мэргэжлийн хяналтын алба;
6. Зэвсэгт хүчин, бусад цэрэг;
7. Татварын алба;
8. Тусгай алба;
9. гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;

10. Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба.

11. Цагдаагийн алба зэрэг байгууллагууд багтдаг.

Гэвч “Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулиар тусгай чиг үүрэгтэй байгууллага улс орны аюулгүй байдлыг хангахдаа хэрхэн хамтрах, мэдээлэл солилцох тухай тусгайлсан журам гараагүй. Иймээс тусгай чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг удирдлагын түвшинд уялдуулан зохицуулахад дараах тулгамдсан асуудал гарч байна.

1. Монгол Улсын Зэвсэгт хүчний, Цагдаагийн албаны, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Гаалийн, Гамшгаас хамгаалах зэрэг хуульд үндэсний аюулгүй байдлын хамтын ажиллагааны үзэл баримтлал тусгагдаагүй.

2. Тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, зохион байгуулалт нь том бүтэцтэй бөгөөд аюул заналын талаар үнэлгээ, таамаглал дэвшүүлдэггүй.

3. Дотоод аюулгүй байдлыг хангах байгууллагууд болзошгүй аюул, эрсдэлийн урьдчилсан анализ хийж, бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллагааны төлөвшил хангалтгүй байна.

4. Хууль сахиулах, хүчний байгууллагуудын хараат бус байдлыг хангах, цалин хангамжийг дээшлүүлэх, зэвсэг хэрэгслийг сайжруулах, цахим технологи, дрон нэвтрүүлэх хэрэгтэй.

5. Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах байгууллагуудын хуульд эрсдэл тооцож, хамтын ажиллагааны нэгдсэн тогтолцоо хэрэгтэй.

6. Үндэсний эв нэгдлийг хангахын тулд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, цагдаагийн байгууллагууд хамтран мэдээлэл солилцох шаардлагатай.

7. Жагсаал, цуглаан ихээр гарч, хүчний байгууллагуудын нэр хүнд унах хандлага ажиглагдаж байна. Цагдаагийн байгууллагууд хүмүүнлэгжсэн хэлбэрт шилжих шаардлагатай.

8. Ковид-19 цар тахалтай тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, нэгдсэн удирдлагыг оновчтой болгох шаардлага тулгарч байна. Зэвсэгт хүчний бүтцэд биотерроризм, биологийн зэвсгийн асуудал хариуцсан нэгж байгуулах шаардлагатай.

Ашигласан материал

Азийн барометр. (2003). Олон улсын ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. Hu Fu Center for East Asia Democratic Studies.

<https://www.asianbarometer.org/>

Энхмаа, Б. (2021). Хүн ам дахь цус ойртолт, үр дагавар, судалгааны тайлан.

Энхмаа, Б., Ариунболд, Ц. (2020). Биотерроризмын аюул занал ба Монгол Улсын био-аюулгүй байдлыг хангах асуудалд.

Эрдэнэдалай, Б. (2020). “Улс төрийн намуудын төлөвшил” судалгааны тайлан.

Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн. (2013). Маргиналь





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

бүлгийн санаа бодлын тандалт судалгаа. Маргиналь бүлгийн санаа бодлын тандалт судалгаа.

Батсуурь, Ж. (2017). Монгол уламжлалт биет бус соёлын өвлөгдөл, гээгдлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд.

Батсуурь, Ж., Энхмаа, Б. (2017). Монгол Улсын хүн амын орон зайн байршил ба нягтралын газарзүйн тархалтын өнөөгийн байдал.

Монгол улсын дээд шүүх. (2021). Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй намуудын жагсаалт. Монгол улсын дээд шүүх. <https://supremecourt.mn/nam>

Стратеги судалгааны хүрээлэн. (2018a). Монгол Улс дахь шашны

байгууллагууд: Төрөл, хэлбэр тархалт судалгааны тайлан. Стратеги судалгааны хүрээлэн.

Стратеги судалгааны хүрээлэн. (2018b). Хүнсний импортын хяналтыг сайжруулах нь. Стратеги судалгааны хүрээлэн.

Стратеги судалгааны хүрээлэн. (2020). Эм, эмчилгээний хэрэгслийн хангамжийн тогтолцоо, эмийн чанарыг сайжруулах нь судалгааны тайлан. Стратеги судалгааны хүрээлэн.

Стратеги судалгааны хүрээлэн. (2021). Монгол Улсын үндэсний эв нэгдэлд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замууд. Стратеги судалгааны хүрээлэн.